

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН 2018 ОНЫ 01 ДУГААР САРЫН 19-НЫ
ӨДРИЙН 19 ДУГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ

УХН11635 5461626

АВЛИГА, ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг.Бодлогын зорилго

1.1. Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны үйл ажиллагааны авлига, залилангийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Банкинд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, авлига, залилангийн үйлдлийн талаар мэдээлэх, авлигагүй байгууллага байхад Бодлогын зорилго оршино.

Хоёр.Бодлогын зорилт

2.1. Бодлогын 1.1-д заасан зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.1.1. шударга, хариуцлагатай, ил тод байдлыг бэхжүүлэх замаар авлига, залилангийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, удирдах ажилтан, ажилтны сонгон шалгаруулалт болон томилгоонд авлигаас ангид, мэдлэг, боловсролд сууринласан мерит зарчмыг хэрэгжүүлэх;

2.1.2. Банкны үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, харилцагчийн эрх ашгийг дээдэлж, ажилтны хариуцлагыг дээшлүүлэх;

2.1.3. санхүү, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, ил тод байдлыг хангах, үр ашигтай төсөлд санхүүжилт хийх, хариуцлагыг дээшлүүлэх;

2.1.4. худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;

2.1.5. авлига, залилангаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ажилтан бүрийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачлагыг дэмжих, авлига, залилангийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд ажилтны оролцоог хангах;

2.1.6. ажилтны мэдээлэл өгөх эрхийг баталгаажуулж, түүний хэрэгжилтийг хангах, шугэл үлээх эрх зүйн орчныг бий болгож, ажилтны ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;

2.1.7. шийдвэр гаргах түвшний үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх үйл ажиллагааг хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;

2.1.8. Банкинд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, ажилтнуудыг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг улирал бүр зохион байгуулж, авлига, залилангийн эсрэг боловсролыг дээшлүүлэх;

2.1.9. авлига, залилантай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.

Гурав.Бодлогын хэрэгжилтэд баримтлах зарчим

3.1. Бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хууль дээдлэх зарчим: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, дүрэм, журмыг дээдэлж, түүнийг хэлбэрэлтгүй сахин биелүүлдэг байх;

3.1.2.хариуцлагатай байх зарчим: Аль ч шатны ажилтан, албан тушаалтан хариуцлага хүлээдэг байх;

3.1.3.ил тод, нээлттэй байх зарчим: Хуульд зааснаас бусад тохиолдолд ажилтны мэдээлэл авах, өгөх эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, Банкны үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, иргэн, хуулийн этгээд хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

3.1.4.нийтийн ашиг сонирхлыг дээдлэх зарчим: Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг бусад ашиг сонирхлоос илүүд үзэн, албан тушаалаа өөрийн болон хамаарал бүхий этгээдийн ашиг олох хэрэгсэл болгохгүй байх;

3.1.5.хамтын ажиллагаа уялдаа холбоотой байх зарчим: Банкны нэгжүүд авлига, залилантай тэмцэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж, хүрэх зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгтгэн тодорхойлж, ажлын уялдаа холбоогоо бэхжүүлэх;

3.1.6.зөрчлийг заавал мэдээлэх зарчим: Авлига, залилангийн шинжтэй үйлдэл, эс үйлдлийн талаар олж мэдсэн ажилтан нь эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэх;

3.1.7.мэдээлэл өгсөн ажилтныг хамгаалах зарчим: Авлига, залилангийн шинжтэй үйлдэл, эс үйлдлийн талаарх мэдээлэл нь мэдээлсэн ажилтныг буруутгах үндэслэл болохгүй байх.

Дөрөв.Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

4.1.1.шударга, хариуцлагатай, ил тод байдлыг бэхжүүлэх замаар авлига, залилангийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилтны ёс зүйг дээшлүүлэх;

4.1.2.авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх;

4.1.3.ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх;

4.1.4.ажилтантай холбоотой мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.5.шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх хариуцлага хүлээлгэх;

4.1.6.авлига, залилангийн эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор авлига, залилангийн хор аюулыг ухуулан таниулах, авлига, залиланг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд Авиалгалтай тэмцэх газраас сургалт авах;

4.1.7.Банкны үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангаж, хуртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх;

4.1.8.эрсдэлд суурилсан дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт, шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах;

4.1.9.Банкны үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах;

4.1.10.мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;

4.1.11.Банкны үйл ажиллагаан дахь үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх, Банкны үйл ажиллагааг харилцагч үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах;

4.1.12.цахим сүлжээг ашиглах замаар авлига, залилангийн үйлдлийн талаарх мэдээллийг авах, мэдээлэл өгч байгаа ажилтныг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх;

4.1.13.мэдээлэл өгч байгаа ажилтныг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.14.аливаа хууль бус нөлөөлөл, түүний хэлбэрүүдийг тодорхойлж, түүнд хулээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.15.авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;

4.1.16.төр, Банк болон Банк, аж ахуйн нэгж хоорондын авлигаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, аливаа санал, санаачлагыг дэмжиж, хамтран ажиллах;

4.1.17.авлигын эсрэг сайн туршлагыг дэлгэрүүлэх.

Тав.Бодлогын хүрэх үр дүн

5.1. Бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

5.1.1.авлига, залилангийн эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх;

5.1.2.үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх;

5.1.3.авлигын эрсдэлийг бууруулж, нэгжүүдийн хамтын ажиллагаа сайжирсан байх;

5.1.4.шударга ёсны үзэл санаа банкинд төлөвшиж, ажилтан өөрт болон бусдад учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль, журмын дагуу шийдвэрлүүлдэг байх сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх;

5.1.5.ажилтны ёс зүй, хариуцлага дээшилсэн байх;

5.1.6.шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх;

5.1.7.үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх;

5.1.8.авлига, залилантай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, залилангийн үйлдлийн талаарх мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад хяналт тавих бололцоо бүрдсэн байх;

5.1.9.авлига, залилангийн үйлдэл, эс үйлдэл гарах шалтгаан нөхцөлийг бууруулсан байх;

5.1.10.авлига, залилантай тэмцэх үйл ажиллагаанд ажилтны оролцоо, хяналт сайжирсан байх;

5.1.11.Банкинд итгэх харилцагчийн итгэл нэмэгдсэн байх.

Зургаа.Хориглох зүйл

6.1. Банк нь дараах этгээдтэй хамтарч ажиллахыг хориглоно:

6.1.1.бизнес, үйл ажиллагаа нь Банкинд шууд болон шууд бусаар хохирол учруулах эрсдэлтэй, Банктай хамтарч ажиллахын тулд Банкны ажилтанд авлига өгөхийг завдсан, шан харамж амласан, зуучилсан этгээд;

6.1.2.Банкны удирдлага, холбогдох хороодын шийдвэр гаргалт, Банкны ажилтнуудын үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг оролдсон, хөндлөнгөөс оролцсон, дарамт,

шахалт үзүүлсэн этгээд;

6.1.3.Банкны нэр хүндийг хууль бус, ёс зүйгүй үйлдэлдээ ашиглахыг завдсан, Банкны ажилтныг албан тушаалаа урвуулан ашиглахыг шаардсан этгээд.

--- 000 ---